



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/84

Мандалговь

Орчны цэвэрлэгээ, мал амьтны сэг
зэмийг цуглуулж устгах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн "а", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 01 албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Бэлчээр, уст цэг, үерийн жалга, усны эх булаг, орон нутгийн төв замын дагуух цэвэрлэгээ, мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах халдваргүйтлийн ажлыг 3 дугаар сарын 30-ны өдрөөс 5 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

Хоёр. Мал амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг гүйцэтгэх ажлын хэсгийг сум, баг бүрт томилон ажиллуулж хүн хүч, техник хэрэгсэлд шаардагдах зардалд дэмжлэг үзүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Гурав. Мэргэжил аргагүй удирдлагаар ханган ажиллаж 2020 оны 5 дугаар сарын 20-ны дотор тайлагнахыг Мал эмнэлгийн газар (Ш.Мөнхдүүрэн), үр дүн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010256